



МОНГОЛ УЛСЫН
АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН
САЙДЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А184

Улаанбаатар хот

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг.Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/87 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам"-д дор дурдсан агуулга бүхий заалт, дэд заалт, үг өгүүлбэр тус тус нэмсүгэй:

1/ "2.1.1. ГСА-ын төсөл гүйцэтгэгч (цаашид "гүйцэтгэгч" гэх) нь" гэсний дараа "өмнөх жилийн хээрийн судалгааны ажлын үр дүнд үндэслэн," гэж, мөн заалтын "... давагдашгүй хүчин зүйл," гэсний дараа "эдийн засгийн хямрал, өргөн хэрэглээний барааны үнийн өсөлт" гэж;

2/ "2.1.1.г/. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдах авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.11-д заасны дагуу ажил гүйцэтгэх гэрээний үнийг тохируулах асуудлыг зохицуулах" гэж;

3/ 2.1.2.а/-ийн "... төсөл гүйцэтгэх хугацаанд хийсэн ажлын" гэсний дараа "үр дүн," гэж;

4/ 2.1.2.б/-ийн "... ажлын хэмжээ, гүйцэтгэл," гэсний дараа "үнийн өөрчлөлт,";

5/ 2.1.2.в/-ийн "... зардлыг ашиглах," гэсний дараа "магадалшгүй ажлын зардлын дүн нь тухайн жилийн төсвийн 3 хувиас хэтрэхгүй байх" гэж;

6/ 3.1.1. дэх заалтын "... бүс нутгийн хөгжлийг жигд хангах," гэсний дараа "хүн амын эрүүл, аюулгүй амьдрах нөхцөл бүхий орчныг бүрдүүлэх" гэж, мөн заалтын "... зангилаануудыг бүрхэх," гэсний дараа "газрын хэвлийн дээр болон доор барилга байгууламж барихтай холбоотой суурь бүтцийн судалгаа хийгдсэн байх" гэж;

7/ "3.2.8.4. Комиссын бүрэлдэхүүн суурин боловсруулалт, хээрийн ажлын гүйцэтгэл, явцад шуурхай хяналт хийх, хээрийн анхдагч материал хүлээн авахаас өмнө хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа, нууцлалын баталгаатай танилцан хүлээн зөвшөөрч баталгаажуулсан байна." гэж;

1508 01 0339

8/ "3.2.18.8. Геологийн судалгааны ажлын тайлан, материалыг хүлээн авах, хадгалах, хамгаалах болон бусад холбогдолтой ажлыг зохион байгуулах зарим чухал шаардлагатай зардал" гэж;

9/ 3.2.24-ийн " ... дэмжлэг үзүүлэх арга хэмжээ" гэсний дараа "яамны геологийн асуудал хариуцсан нэгж болон гэж";

10/ "3.2.26. МСК болон РЗ-ийн тухайн жилийн төлөвлөгөөг яамны геологийн асуудал хариуцсан нэгжээр хянуулсны үндсэн дээр ҮГА-ны дарга жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор батална." гэж;

11/ "3.2.27. Гүйцэтгэгч нь төслийн ахлагч, голлох мэргэжилтэн өөрчлөгдсөн тухай бүр ҮГА-д шуурхай мэдээлж баталгаажуулсан байна." гэж;

12/ "4.1.8. ЭБМЗ-ийн хуралдааны тэмдэглэл, дүгнэлтийг үндэслэн сайд ГСА-ын үр дүнгийн тайланг хүлээн авах эсэх тухай шийдвэр гаргана." гэж;

13/ "4.1.12.3/ ГСА-ын гэрээ дүгнэсэн актыг заасан хугацаанд үйлдээгүй" гэж;

14/ "4.1.15. ҮГА нь ГСА гүйцэтгэх гэрээг дүгнэсэн акт болон энэ журмын 12 дугаар хавсралтын дагуу үйлдсэн төсвийн нэгтгэлийн хамт яамны холбогдох нэгжүүдэд тухай бүр хүргүүлнэ." гэж.

Хоёр. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/87 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам"-ын дараах хэсэг, заалтуудыг дор дурдсанаар тус тус өөрчлөн найруулсугай:

1/ 2.1.6 дахь заалтын "ГСА-ын тухайн жилийн төсөвт батлагдсан магадалшгүй ажлын зардлыг тухайн төслийг гүйцэтгэх явцад гарсан урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөлийн улмаас ашиглах гүйцэтгэгчийн санал, баримт нотолгоог шуурхай хяналтын тэмдэглэлээр баталгаажуулж, энэ талаар хэлэлцсэн ЭБМЗ-ийн дүгнэлтийг үндэслэн ҮГА шийдвэрлэнэ." гэснийг "2.1.6.ГСА-ын тухайн жилийн төсөвт батлагдсан магадалшгүй ажлын зардлыг зарцуулах асуудлыг хээрийн ажлын явцад шинээр бий болсон баримтад тулгуурлан гаргасан гүйцэтгэгчийн саналд үндэслэн шуурхай хяналтын комисс газар дээр нь шийдвэрлэнэ. Комисс нь энэ тухай илтгэх хуудаст тэмдэглэж ҮГА-д танилцуулна. " гэж ;

2/ 3.2.2 дахь заалтын "Гүйцэтгэгч нь төслийн хүрээнд бусдаар гүйцэтгүүлэх геофизикийн судалгааны ажлын арга аргачлалыг ҮГА-нд хянуулна. Мөн ажлын хэрэгцээний байр зүйн зураг, агаар болон сансрын зураг, түүний тоон мэдээлэл, тайлангийн зургуудыг ҮГА-ны гео-мэдээллийн төвөөс захиалан хэвлүүлж авна." гэснийг "3.2.2. Гүйцэтгэгч нь төслийн хүрээнд бусдаар гүйцэтгүүлэх геофизик болон бусад ажлын арга аргачлалыг ҮГА-нд хянуулна. Мөн ажлын хэрэгцээний байр зүйн зураг, агаар болон сансрын зураг, урд өмнө нь тухайн төслийн талбайд хийгдсэн геологийн судалгааны ажлын тоон мэдээлэл, тайлангийн зургуудыг ҮГА-ны гео-мэдээллийн төвөөс захиалан цахим болон биет байдлаар авна." гэж;

3/ 3.2.3 дахь заалтын "Гүйцэтгэгч нь УТХ-өөр гүйцэтгэсэн ГСА-ын дээж, сорьцын шинжилгээг "Геологийн төв лаборатори"ТӨҮГ-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлнэ. Дээж, сорьцын шинжилгээг өөр бусад итгэмжлэгдсэн лабораториор гүйцэтгүүлэх зайлшгүй шаардлагатай бол ҮГА-нд мэдэгдэнэ." гэснийг "3.2.3.

Гүйцэтгэгч нь УТХ-өөр гүйцэтгэсэн ГСА-ын дээж, сорьцын шинжилгээг Олон улсын лабораторийн итгэмжлэлийн байгууллага, үндэсний стандарт, хэмжилзүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын аль нэгний олгосон хүчин төгөлдөр итгэмжлэл бүхий судалгааны лабораторитой болон байгууллагатай гэрээ байгуулан гүйцэтгүүлнэ.” гэж;

4/ 3.2.18 дахь заалтын “Шуурхай хяналт, хээрийн материал хүлээн авах, судалгааны ажлын явцад гарсан маргаантай асуудлыг шийдвэрлэх, ГСА-ын арга, аргачлал, заавар, зөвлөмж, норм боловсруулах, хэвлэн нийтлэх, хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлэг зохион байгуулах, хяналтад шаардагдах тоног төхөөрөмж, багаж худалдан авах, МСК, РЗ, ЭБМЗ-ийн геологийн судалгааны асуудал хэлэлцэх салбар зөвлөлийн үйл ажиллагаа, гишүүд, шинжээчийн зардал, ГСА-ыг чанартай гүйцэтгэсэн гүйцэтгэгчийг урамшуулан шагнах зардлыг ГСА-ын аргачлал, хяналтын зардлаас санхүүжүүлнэ.” гэснийг “3.2.18. ГСА-ын аргачлал, хяналтын зардлаас дараах нэр бүхий үйл ажиллагааг санхүүжүүлнэ;:

3.2.18.1. Шуурхай хяналт, хээрийн материал хүлээн авах, судалгааны ажлын явцад гарсан маргаантай болон тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зардал, хяналтын дээж, сорьц авах, түүний лабораторийн шинжилгээний зардал;

3.2.18.2. ГСА-ын төсөв зохиох, төлөвлөх, даалгавар, арга, аргачлал, заавар, зөвлөмж, норм боловсруулах, хэвлэн нийтлэх зардал;

3.2.18.3. ГСА-тай холбоотой дотоодын болон олон улсын хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлэг зохион байгуулах, оролцох зардал;

3.2.18.4. ГСА-ын суурин боловсруулалт, хээрийн ажлын гүйцэтгэл, явцад шуурхай хяналт хийх, хээрийн анхдагч материал хүлээн авах, хяналт тавихад шаардагдах техник, тоног төхөөрөмж, багаж, хувийн хамгаалах хувцас хэрэгсэл худалдан авах зардал;

3.2.18.5. МСК, РЗ, ЭБМЗ-ийн геологийн судалгааны асуудал хэлэлцэх салбар зөвлөлийн үйл ажиллагаа, гишүүд, шинжээчийн зардал;

3.2.18.6. ГСА-ыг чанартай гүйцэтгэсэн гүйцэтгэгчийг урамшуулан шагнах зардал;

3.2.18.7. Гео шинжлэх ухааны байгууллагуудаас хамтран ажиллах гадаадын болон дотоодын эрдэмтэн, судлаач, мэргэжилтний зардал.” гэж;

5/ 3.2.25 дахь заалтын “Шуурхай хяналт хийх, хээрийн материалыг хүлээн авах хяналтын хуудас болон улирлын тайлан хүлээн авах маягтыг ҮГА-ны дарга батална.” гэснийг “3.2.25. Шуурхай хяналт хийх болон хээрийн материал хүлээн авах удирдамж, ГСА-ын улирлын тайлан хүлээн авах маягтыг ҮГА-ны дарга батална.” гэж;

6/ 4.1.5 дахь заалтын “ГСА-ын хэмжээнээс хамаарч үр дүнгийн тайланд дүгнэлт, зөвлөмж, санал гаргах хугацааг ажлын 5 хүртэл хоногоор сунгаж болно.” гэснийг “4.1.5. ГСА-ын хамрах хүрээ, ажлын хэмжээнээс хамаарч үр дүнгийн тайланд дүгнэлт, зөвлөмж, санал гаргах хугацааг бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн тус бүр ажлын 10 хүртэл өдрөөр сунгаж болно.” гэж;

7/ 4.1.9 дэх заалтын “ЭБМЗ-ийн хуралдааны тэмдэглэл, дүгнэлтийг үндэслэн сайд ГСА-ын үр дүнгийн тайланг хүлээн авах эсэх шийдвэр гаргана. Сайдын

шийдвэрийг үндэслэн судалгааны ажлын үр дүнгийн тайлан, анхдагч материалыг 11 дүгээр хавсралтын дагуу Геологийн баримтын төв архив (цаашид "ГБТА" гэх) хүлээн авч УГА-ны асуудал хариуцсан нэгжид тухай бүр мэдэгдэнэ." гэснийг "4.1.9. Сайдын шийдвэрийг үндэслэн судалгааны ажлын үр дүнгийн тайлан, анхдагч материалыг энэ журмын 11 дүгээр хавсралтын дагуу Геологийн баримтын төв архив (цаашид "ГБТА" гэх) хүлээн авч, ажлын 5 өдөрт багтаан холбогдох журам, зааврын дагуу бүртгэн УГА-ны асуудал хариуцсан нэгжид мэдэгдэнэ. Бүртгэгдэж, мэдэгдсэн, нууцад хамрагдаагүй тайлан, анхдагч материалыг батлагдсан тарифт үнээр нийтийн хэрэгцээнд үйлчилнэ." гэж;

8/ 4.1.10 дахь заалтын "ГБТА нь тайлан, анхдагч материалыг хүлээн авах тухай сайдын шийдвэрийг хүлээн авч, түүний дагуу гүйцэтгэгчээс энэ журмын 4.1.9-д заасан зүйлсийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор багтаан өөрийн архивын үйлчилгээний мөрдөх журам, зааврын дагуу бүртгэлд тусган баримтжуулснаар нийтийн хэрэгцээнд батлагдсан тарифт үнээр үйлчилнэ." гэснийг "4.1.10. Тайлан, холбогдох материалыг ГБТА-т хүлээлгэн өгсөн мэдэгдлийг үндэслэн ажлын 10 өдөрт багтаан захиалагч болон гүйцэтгэгч талууд гэрээг дүгнэсэн акт үйлдэнэ." гэж;

9/ "4.1.15. ГСА-ын үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцээд засвар, өөрчлөлт хийлгэхээр буцаасан хугацаа хэтэрсэн тохиолдолд хоног тутамд энэ журмын 4.1.14-д заасан алдангийг мөн адил тооцно." гэснийг "4.1.14. ГСА-ын үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцээд засвар, өөрчлөлт хийлгэхээр буцаан шийдвэрлэсэн хугацааг хэтрүүлсэн тохиолдолд хоног тутамд энэ журмын 4.1.13-д заасан алдангийг мөн адил тооцно." гэж;

Гурав. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/87 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам"-ын дараах заалтуудыг дор дурдсанаар өөрчилсүгэй:

1/ 1.3 дахь хэсгийн "... геозкологийн зураглал ..." гэснийг "тектоник, геозкологи, гео-гамшиг, гео-орчин, хот суурингийн геологи, инженер геологийн зураглал" гэж;

2/ 2.1.1 дэх заалтын "... жил бүрийн 01 дүгээр сарын 20-ны ..." гэснийг "... жил бүрийн 01 дүгээр сарын 30-ны ..." гэж;

3/ 2.1.1.а/ дэх заалтын "төсөл гүйцэтгэх геологийн даалгаврын хугацааг сунгуулах болон зөвлөх үйлчилгээний гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах" гэснийг "Ажил гүйцэтгэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах" гэж;

4/ 2.1.3 дахь заалтын "... жил бүрийн 2 дугаар сарын 20-ны өдрийн дотор хянаж, 3 дугаар сарын 25-ны ..." гэснийг "... жил бүрийн 2 дугаар сарын 25-ны өдрийн дотор хянаж, 3 дугаар сарын 31-ний ..." гэж;

5/ 2.1.8 дахь заалтын "... 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор" гэснийг "12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ..." гэж;

6/ 2.2.1. дэх заалтын "... 6 дугаар ..." гэснийг "Аж, үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны А/84 дүгээр тушаалаар баталсан" гэж;

7/ 2.3.1 дэх заалтын "... сар болгоны ..." гэснийг "... ажил гүйцэтгэх гэрээний дагуу ..." гэж;

8/ 2.3.2 дахь заалтын "... сар бүрийн ..." гэснийг "... ажил гүйцэтгэх гэрээнд заасан хуваарийн дагуу тухайн сарын ..." гэж;

9/ 3.1.1. дэх заалтын "... бодлого, хууль, тогтоомж, ..." гэснийг "... хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, ..." гэж;

10/ 3.1.3 дахь заалтын "... 12 дугаар сарын 15-ны өдрийн ..." гэснийг "... 12 дугаар сарын 01-ний өдрийн ..." гэж;

11/ 3.1.9 дэх заалтын "... 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор хянуулж 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн дэд сайдаар батлуулна." гэснийг "... 01 дүгээр сарын 30-ны өдрийн дотор хянуулж 02 дугаар сарын 20-ний өдрийн дотор яамны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулна." гэж;

12/ 3.2.9 дэх заалтын "... гүйцэтгэгч нарыг ..." гэснийг "... захиалагчийн санал болон гүйцэтгэгчийн бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн ..." гэж;

13/ 3.2.15 дахь заалтын "... саналыг комисс газар дээр нь хянан баталгаажуулна. Тус комисс нь тухайн төслийн ажилд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналын үндэслэл, хийх арга замыг тодорхой дурдсан илтгэх хуудас боловсруулан ҮГА-нд хүргүүлж шийдвэрлүүлнэ." гэснийг "... санал нь үндэслэлтэй байгаа тохиолдолд комисс тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд асуудлыг газар дээр нь шуурхай шийдвэрлэнэ. Комисс нь энэ тухай илтгэх хуудаст дэлгэрэнгүй тусган ҮГА-д хүргүүлж, танилцуулна." гэж;

14/ 3.2.16 дахь заалтын "... саналыг комиссын гишүүдийн олонхийн саналаар ҮГА-нд хүргүүлж шийдвэрлүүлнэ." гэснийг "... шийдвэрийг комисс газар дээр нь гаргаж шийдвэрлэнэ. Энэ тухай комисс нь үндэслэл, баримтаар нотлон дэлгэрэнгүйгээр илтгэх хуудаст тусган ҮГА-д танилцуулж, баталгаажуулна. Үүссэн зөрчил ноцтой бөгөөд төслийн ажлын эцсийн үр дүн шууд нөлөөлөхүйц хохиролтой тохиолдолд төслийн ажлыг зогсоох саналыг комиссын гишүүдийн олонхийн саналд үндэслэн гаргаж, энэ тухай ҮГА-нд мэдэгдэн шийдвэрлүүлнэ." гэж;

15/ 4.1.1 дэх заалтын "... ҮГА болон яамны асуудал хариуцсан мэргэжилтнүүдээр хянуулж шаардлагатай засвар, өөрчлөлтийг хийсний үндсэн дээр ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхээр албажуулан хүргүүлнэ." гэснийг "... шаардлагатай засвар, нэмэлт өөрчлөлтийг хийсний үндсэн дээр ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхээр албажуулан ҮГА-д хүргүүлнэ. Ирүүлсэн тайлан болон бусад холбогдох материалыг ҮГА болон яамны асуудал хариуцсан мэргэжилтнүүдээр хянуулж шаардлагатай засвар, өөрчлөлтийг хийсний дараа ЭБМЗ-өөр хэлэлцүүлнэ." гэж;

16/ 4.1.3 дахь заалтын "... геологийн даалгаварт заасан хугацаанд ..." гэснийг "... тус бүр ГСА-ын даалгавар, төсөл хэрэгжүүлэх гэрээнд заасны дагуу 30 хоногт багтаан ..." гэж;

17/ 4.1.4 дэх заалтын "... 10 хоногт ..." гэснийг "... 5 өдөрт ..." гэж;

18/ 4.1.6 дахь заалтын "... 3 хоногт ..." гэснийг "... 10 өдөрт ..." гэж;

19/ "4.1.8" гэснийг "4.1.7" гэж;

20/ "4.1.11 дэх заалтыг хүчингүй болгож, 4.1.12 гэснийг 4.1.11 гэж";

21/ 4.1.13.е/ дэх заалтын "... 3-аас дээш удаа өөрчилсөн нь ГСА-ын чанар, үр дүнд сөрөг нөлөө үзүүлсэн." гэснийг "... захиалагчид мэдэгдэлгүй өөрчилсөн." гэж;

22/ 4.1.13.ё/ дахь заалтын "... хамгаалаагүй," гэснийг "... хэлэлцүүлэхээр ирүүлээгүй," гэж;

23/ "4.1.13" гэснийг "4.1.12" гэж, "4.1.13.а/" гэснийг "4.1.12.а/" гэж, "4.1.13.б/" гэснийг "4.1.12.б/" гэж, "4.1.13.в/" гэснийг "4.1.12.в/" гэж, "4.1.13.г/" гэснийг "4.1.12.г/" гэж, "4.1.13.д/" гэснийг "4.1.12.д/" гэж, "4.1.13.е/" гэснийг "4.1.12.е/" гэж, "4.1.13.ё/" гэснийг "4.1.12.ё/" гэж, "4.1.13.ж/" гэснийг "4.1.12.ж/" гэж;

24/ "4.1.14" гэснийг "4.1.13" гэж.


Дөрөв. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/87 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам"-ын 1.2 дахь хэсгийн "Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам" гэснийг, мөн журмын 4.1.7 дахь заалтыг тус тус хассугай.

Тав. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын "Журам шинэчлэн батлах тухай" 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/87 дугаар тушаалын 6 дугаар хавсралтаар баталсан "Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа геологийн судалгааны төслийн ажлын гүйцэтгэлийн хүснэгт"-ийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

Зургаа. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын "Журам шинэчлэн батлах тухай" 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/87 дугаар тушаалын 6 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

Долоо. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/87 дугаар тушаалын 1 ба 6 дугаар хавсралтад оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, Захиргааны хэм хэмжээний нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг Төрийн нарийн бичгийн дарга (С.Жавхланбаатар)-д үүрэг болгосугай.

Найм. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Үндэсний геологийн алба (П.Батцацрал)-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (С.Жавхланбаатар)-д тус тус даалгасугай.



Ц.ТУВААН

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025
оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн
1/84 дүгээр тушаалын хавсралт

Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа геологийн судалгааны
..... (төслийн нэр) төслийн ажлын гүйцэтгэл

20... оны ... дугаар сарын 01-ээс
... дугаар сарын 30-ны өдөр хүртэл

Гэрээний дүн: төгрөг

№	Ажлын нэр, төрөл	Хэмжих нэгж	Нэгжийн өртөг	Тухайн жилийн ажлын хэмжээ*		Тайлант сарын гүйцэтгэл		Оны эхнээс гарсан гүйцэтгэл	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
0	1	2	3	4	5	6	7	8	9
1									
...									
Нийт									

***- шинээр эхлэх төсөлд эхний жилийн ажлын хэмжээ, мөнгөн дүнг,
үргэлжилж буй төсөлд тодотголын ажлын хэмжээ, мөнгөн дүнг үзүүлнэ.**

Гүйцэтгэгч:

... компанийн захирал/...../
/тамга/
... компанийн эдийн засагч, нягтлан бодогч/...../
... төслийн ахлагч/...../

Танилцсан:

ҮГА-ны геологийн асуудал хариуцсан
нэгжийн дарга/...../

Хянасан:

ҮГА-ны геологийн асуудал хариуцсан
нэгжийн мэргэжилтэн/...../

ҮГА-ны геологийн санхүү, төсвийн гүйцэтгэл хариуцсан
нэгжийн мэргэжилтэн/...../